


## Ипотекийн зээлийн тайлан

2015 оны 11 дүгээр сар


Банкууд 2015 оны 11 дүгээр сард нийт 1075 зээлдэгчид 69.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 3412.9 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 76583-д хүрчээ.

Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 1.1 нэгж хувиар, оны эхнээс 23.2 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 27.1 нэгж хувиар буурсан байна.



Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.3 хувь буюу 2570.2 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 22.8 хувь буюу 777.5 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.9 хувь буюу 65.2

тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.



2015 оны 11 дүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.5 хувь нь төгрөгийн зээл, 1.5 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2015 оны 11 дүгээр сарын байдлаар 2.5 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 0.7 байна.



### Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 13.9 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.9 хувиар буурсан байна.




Тайлант сард шинээр олгосон зээлийн 66.6 хувь буюу 46.1 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 33.4 хувь буюу 23.1 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.



Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2015 оны 11 дүгээр сарын байдлаар 64.4 сая төгрөг байна.

Тухайн сард 26.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх сараас 8.7 хувиар буурсан ч өмнөх оны мөн үеэс 15.3 хувиар өсчээ.



**Зээлдэгчдийн тоо**

Тайлант сард нийт 1075 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 769 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 306 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



2015 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 76583 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 55295 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог


бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 19335 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 1953 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



**Зээлийн хугацаа**

Тайлант сард банкууд 0.5-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 16.4 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2015 оны 11 дүгээр сарын байдлаар 15.6 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 52.5 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 68.0 хувь нь 16-20 жил, 19.2 хувь нь 11-15 жил, 10.7 хувь нь 6-10 жил, 2.1 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.



**Зээлийн хүү**

Банкуудын 2015 оны 11 дүгээр сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж 10.0 хувь байв. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 6.6 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 14.0 хувь байв.

## Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар)	Тухайн сард олгосон зээлийн ЖДХүү, жилээр (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл				ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй
2008	12	217,977.5		100.7	19.8	16,522	
2009	12	226,040.6		103.4	18.7	16,784	
2010	12	333,776.6		115.0	16.0	16,700	
2011	12	669,662.8		154.3	14.8	26,869	
2012	12	845,204.4		155.5	15.3	29,887	
2013	12	1,938,945.3	1,248,633.8	192.8	9.9	48,320	30,600
2014	1	2,021,424.9	1,324,898.9	194.4	9.8	49,731	32,190
	2	2,121,802.6	1,382,084.1	193.2	9.9	53,611	33,346
	3	2,193,368.6	1,451,938.1	190.7	9.9	54,787	34,632
	4	2,280,503.5	1,538,506.8	192.1	9.8	56,137	36,081
	5	2,365,349.5	1,618,127.2	189.3	10.0	57,579	37,488
	6	2,440,007.1	1,684,583.9	182.3	10.5	58,793	38,659
	7	2,492,105.2	1,728,222.8	187.9	10.7	59,756	39,507
	8	2,553,827.2	1,780,078.3	186.7	10.5	60,851	40,405
	9	2,619,161.1	1,833,494.0	185.9	10.6	62,017	41,390
	10	2,703,792.6	1,903,636.6	189.3	10.4	63,652	42,772
	11	2,762,726.8	1,954,341.3	194.5	10.3	64,577	43,621
	12	2,844,706.3	2,027,952.9	200.1	9.9	66,334	45,283
2015	1	2,898,731.0	2,072,894.5	195.9	10.2	67,233	46,134
	2	2,949,116.5	2,121,339.7	198.6	9.7	68,126	47,108
	3	3,015,535.1	2,196,795.5	197.7	9.2	69,269	48,512
	4	3,082,551.7	2,263,794.5	199.2	9.6	70,498	49,691
	5	3,128,182.4	2,305,308.1	197.3	10.3	71,355	50,462
	6	3,192,029.1	2,363,999.7	197.2	9.6	72,412	51,438
	7	3,230,507.8	2,400,625.2	193.2	9.9	73,208	52,181
	8	3,267,175.5	2,433,968.6	195.1	10.0	73,949	52,858
	9	3,319,711.8	2,481,556.8	194.8	9.6	74,848	53,643
	10	3,370,510.2	2,534,505.4	202.1	9.4	75,877	54,612
	11	3,412,929.6	2,570,150.9	196.5	10.0	76,583	55,295

## Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2015 оны 10 дугаар сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Гухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХугацаа (сар)	Гухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБХ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,594,614.9	77.0%	1,917,080.5	75.6%	205.3	9.3	51538	50,236
2 Дархан-Уул	115,234.9	3.4%	101,139.4	4.0%	222.1	9.0	3382	475
3 Орхон	109,001.4	3.2%	95,062.9	3.8%	187.1	9.5	2892	456
4 Дорноговь	69,723.2	2.1%	57,264.7	2.3%	204.3	8.5	2025	485
5 Дорнод	47,965.2	1.4%	42,779.8	1.7%	203.6	8.6	1530	363
6 Сэлэнгэ	45,834.7	1.4%	36,181.2	1.4%	183.0	8.7	1569	175
7 Өвөрхангай	43,016.3	1.3%	30,372.5	1.2%	186.0	11.5	1513	252
8 Увс	41,995.4	1.2%	29,884.6	1.2%	182.4	13.2	1402	199
9 Өмнөговь	41,050.9	1.2%	31,138.9	1.2%	191.4	9.2	1144	250
10 Баянхонгор	33,052.2	1.0%	29,632.5	1.2%	208.1	8.4	875	272
11 Ховд	31,814.3	0.9%	26,411.6	1.0%	182.2	9.1	1072	265
12 Сүхбаатар	26,148.2	0.8%	17,526.1	0.7%	155.1	13.9	893	170
13 Архангай	23,142.2	0.7%	18,136.3	0.7%	184.8	9.6	682	128
14 Баян-Өлгий	21,693.8	0.6%	11,041.0	0.4%	159.7	12.3	1071	84
15 Говь-Алтай	18,963.1	0.6%	15,436.2	0.6%	202.3	8.0	614	135
16 Завхан	17,971.7	0.5%	11,261.7	0.4%	194.4	8.9	680	81
17 Хөвсгөл	17,906.1	0.5%	9,622.2	0.4%	161.8	10.9	719	87
18 Хэнтий	16,631.9	0.5%	14,104.4	0.6%	195.8	11.0	488	144
19 Төв	14,965.3	0.4%	11,114.1	0.4%	192.0	8.0	469	99
20 Дундговь	14,786.0	0.4%	11,313.9	0.4%	176.4	11.5	467	97
21 Говьсүмбэр	12,567.4	0.4%	11,228.2	0.4%	157.4	8.3	404	102
22 Булган	12,431.2	0.4%	6,772.7	0.3%	172.5	12.5	448	57
<b>Нийт</b>	<b>3,370,510.2</b>	<b>100%</b>	<b>2,534,505.4</b>	<b>100%</b>	<b>202.1</b>	<b>9.4</b>	<b>75877</b>	<b>54612</b>

2015 оны 10 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.0 хувийг Улаанбаатар хотод, 23.0 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 14.9 хувь буюу 115.2 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 14.0 хувь буюу 109.0 тэрбум төгрөг Орхон аймагт, 9.0 хувь буюу 69.7 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.